



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 463

Улаанбаатар хот

**Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай**

“Орхон-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн 2017, 2018 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт заасныг зөрчиж нийт 67,602,000.00 /жаран долоон сая зургаан зуун хоёр мянган/ төгрөгийн төлбөр, зөрчлүүд гарсныг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Орхон-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Орхон-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1. “Орхон А33А” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Цогтгэрэл нь компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 00-21 ОРО улсын дугаартай ланд круйзер-100 маркын автомашиныг өөрийн төрсөн хүү Ц.Гантулгад 2019 оны 3 дугаар сараас 8 дугаар сар хүртэл унуулан, төрийн өмчийн эд хөрөнгийг дур мэдэн, зориулалтын бусаар ашиглаж байсан нь шалгалтаар тогтоогдсон тул Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.4-т заасан үндэслэлээр хөдөлмөрийн харилцааг цуцлах;

2.2. Дээрх авто машиныг ашиглахтай холбогдуулан гарсан зардлыг хууль тогтоомжийн дагуу Б.Цогтгэрэлээр нөхөн төлүүлэх;

2.3. Шалгалтаар илэрсэн холбогдох зөрчил дутагдалд, хяналт тавьж ажиллах үүргээ хангалтгүй биелүүлсэн “Орхон-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн ерөнхий нягтлан бодогч, эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцох;

2.4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дотоод хяналтыг сайжруулах, хяналт шалгалтыг тогтмолжуулах;

3. “Орхон А33А” ТӨХК-ийн гүйцэтгэх захиралд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

3.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч цаашид анхан шатны баримт дутуу, баримтгүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх, санхүүгийн тайланд тусгахгүй байх;

3.2. Байгууллагад хөтлөгдөж буй баримт бичиг, гэрээ, эрхийн актуудыг архивын тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн журам зааврын дагуу бүрдүүлэх, хадгалах;

3.3.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн
463 дугаар тогтоолын хавсралт



“Орхон-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанид
хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Хамрах хугацаа	Үнийн дүн /сая төгрөг/	Зөрчигдсөн эрх зүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1. Худалдан авалт, гэрээ, хэлцэлтэй холбоотой зөрчил					
1	Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэсэн.	2017	67.6	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт	Анхан шатны баримт дутуу, баримтгүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх, санхүүгийн тайланд тусгахгүй байх
	НИЙТ ДҮН:		67.6		

“ОРХОН АЗЗА” ТӨХК-ИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

2019 оны 09 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг зүйл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт заасныг үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын баталсан 2019 оны хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу “Орхон-АЗЗА” ТӨХК 2017-2018 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд Төрийн өмчийн бүртгэл хяналтын мэргэжилтэн, санхүүгийн хяналтын улсын ахлах байцаагч Н.Ган-Эрдэнэ, мэргэжилтэн Т.Анхбаяр нар баримтын шалгалт хийлээ.

Шалгалтаар тус байгууллагын газрын санхүү, эдийн засаг, үр ашгийн байдал, төрийн өмчийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, захиран зарцуулалт, хөрөнгөд бүртгэлээр тавьж буй хяналт, захиралтай байгуулсан гэрээ болон “Төрийн өмч эзэмшүүлэх гэрээ”-ээр хүлээсэн үүргийн хэрэгжилт явц, өр авлага түүний барагдуулалт, тооцоо нийлсэн акт, байгууллага аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээ хэлцэл, худалдан авалтын үйл ажиллагаа зэргийг шалгаж, дүгнэлт гаргав.

Төрийн өмчийн хорооны 2012 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн 274 дүгээр тогтоолоор тус компанийн дүрмийг баталсан энэхүү дүрэмд компанийн зарласан үнэ нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 2,550,285 ширхэг энгийн хувьцаанаас бүрддэг гэж заасан байна.

Тус компани нь Төрийн банканд 130400020778 тоот, 340502042800 харилцах данснудтай, мөн Капитал банканд 2035008121 тоот харилцах данс, худалдаа хөгжлийн банканд 407129784 тоот харилцах дансаар дамжуулан үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний орлого, зарцуулалтыг хийж ирсэн ба хяналт шалгалтад хамрагдсан тайлант хугацаанд гарын үсгийн нэгдүгээрийг “Орхон-АЗЗА” ТӨХК-ний гүйцэтгэх захирал Х.Батболд, хоёрдугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч Ч.Жаргалмаа нар зурж хөрөнгө, мөнгийг захиран зарцуулж ирсэн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 609 дүгээр тогтоолоор 45 орон тоо 449.8 сая төгрөгийн цалингийн сан баталсан байна.

Хоёр. Товч танилцуулга, үндсэн үйл ажиллагаа

Эрдэнэт хотын Зам анги нь 1979 онд Хот хоорондын авто тээврийн 35-р бааз харьяа замын хэсэг нэртэйгээр анхны сууриа тавьсан. “Орхон АЗЗА” ТӨХК нь 1981 онд Булга аймгийн зам барилга конторын мэдэлд шилжиж зам засвар арчлалтын ажлыг хийж байжээ. Тус оны 11 дүгээр сард Монгол Улсын Сайд нарын зөвлөлийн 320 дугаар тогтоол гарч авто замчид мэргэжлийн удирдлагаар хангагдах нөхцөл бүрдэж авто зам гүүрний барилга ашиглалтын ажлыг эрхэлсэн төв орон нутгийн байгууллага байгуулагдаж боловсон хүчин, техник хэрэгслээр хангагдаж 1982 оны 01 дүгээр сарын 01-ны өдөр “Эрдэнэт хотын зам барилга ашиглалтын анги” өрх тусгаарлан “Дархан-Эрдэнэтийн 108 км, Хялганатын 65 км, Эрдэнэт-Булган 30 км, хайрган хучилттай замын засвар арчлалт, хотын төвийн доторх зам, Ингэт толгойн САА-н Ургац тээврийн зам, Атарын САА-н Хулстайн гурван давааны ургацын замыг арчилж байх үүрэгтэй ажиллаж байжээ. Төрийн өмчийн хорооны 2006 оны 640 дүгээр тогтоолоор авто замын байгууллагуудад бүтцийн өөрчлөлт хийж бие даасан компаниуд байгуулахтай холбоогдуулан тусдаа гарч “Орхон-АЗЗА” ТӨХК нэртэйгээр улсын бүртгэлийн 000133873 тоот гэрчилгээтэй, 4369963 тоот

регистртэй, Авто зам, замын байгууламжийг барих, засварлах Б 16/137 тоот тусгай зөвшөөрөлтэй Олон улс болон улсын чанартай Дархан-Эрдэнэтийн чиглэлийн 108 км улсын чанартай авто зам, Эрдэнэ-Булганы чиглэлийн 29,7 км гэсэн 2 чиглэлийн 137,7 км авто зам, замын байгууламжийн засвар арчлалт хийх үндсэн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

“Орхон-АЗЗА” ТӨХК нь төрийн өмчид тулгуурлан замын сангийн хөрөнгөөр гэрээний үндсэн дээр авто замын засвар арчлалтыг хариуцан ---- машин механизмтайгаар хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна.

2017 онд 819.97 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Улсын чанартай зам засвар арчлалтын ажлыг гэрээний дагуу хийж гүйцэтгэснээс гадна Орхон аймгийн замын сангийн хөрөнгөөр 680.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 ажилд гүйцэтгэгчээр сонгогдон гэрээ байгуулж барилгын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

2018 онд Улсын чанартай 755.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зам засвар, арчлалтын гэрээ байгуулж графикийн дагуу хийж гүйцэтгэсэн.

**Гурав. 2017-2018 оны санхүү эдийн засгийн үйл ажиллагаа,
зорилтот түвшингийн төлөвлөгөөний биелэлт:**

“Орхон-АЗЗА” ТӨХК –ийн 2017-2018 оны зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг дараах байдлаар баталсан байна. Үүнд:

Д/ д	Үзүүлэлтүүд	Хэмжиг нэгж	2017 он		Харь/ хувь	2018 он		Харь/ хувь
			Төлөв	Гүйц		Төлөв	Гүйц	
1	НИЙТ ОРЛОГО		1169810	1146575.2	98.01	1368000	1020057.6	74.56
	Борлуулалтын орлого	мян/төг	1169810	1146575.2	98.01	1368000	1020057.6	74.56
2	Нийт зардал	мян/төг	1143293.6	1121930.3	98.13	1334271.8	1344950.63	100.8
	7.1 Үүнээс: удирдлагын зардал	мян/төг	175410.8	174828.6	99.66	213672.4	227033.75	106.25
3	Татварын өмнөх ашиг (алдагдал)	мян/төг	26516.4	24644.9	92.94	33728.2	(320949.64)	(951.57)
4	Цэвэр ашиг (алдагдал)	мян/төг	26516.4	22180.41	83.64	30355.38	(343167.33)	(1130.49)
5	ТӨНА	мян/төг	2651.64	2218.04	83.64	3035.53	0	0
6	Бор-ын 1 төг-т ногдох зардал	мян/төг	0.98	0.98	100	0.98	1.32	134.69
7	Нийт авлага	мян/төг	11200	344407.06	3075	22080	203727.9	922.68
8	Нийт өр төлбөр	мян/төг	633393.5	1039411.08		641143.5	865197.8	134.94
9	Үүнээс: БХӨТ	мян/төг	6500	412517.12	6346.42	14250	238304.3	1672.31
10	Хөрөнгө оруулалт, их засвар,	мян/төг	58495	39040	66.74	95240	5408	5.67
11	Нийт ажиллагсдын тоо	мян/төг	45	41	91.1	45	43	95.5
12	Нийт цалингийн сан	мян/төг	449005	396858.2	88.38	449839.4	398959.52	88.68
13	Элэгдлийн зардал	мян/төг	145101.2	152322.3	104.97	159600.7	102610.7	64.29

2017-2018 онуудад тус компани эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн төлөвлөгөөг биелүүлээгүй байна. Төлөвлөгөө биелээгүй шалтгаан нь 2016 оноос хойш хуримтлагдсан татварыг өр байгаа тул Орон нутгаас зарласан ямар нэгэн тендерт оролцох эрхгүй болж ажил авч чадахгүй байгаа нь 2018 оны орлогын төлөвлөгөө тасарсан нь гол шалгаан болсон байна.

Төлөвлөгөөний биелэлт хангалтгүй байгаа нь орлого, зардал, цэвэр ашиг, алдагдлын төлөвлөлт үндэслэл муутай, эдийн засгийн тооцоо судалгаагүй, өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулаагүй явж ирсэнтэй холбоотой байна.

2017 онд тус компанийн нягтлан нь тайлан балансаа ашигтай гаргахын тулд тухайн жилийн зардалд тусгагдах ёстой байсан бараа материалыг бэлнээр тоолж тайлан балансаа гаргасан нь ашигтай ажилласан мэт харагдуулж гүйцэтгэх захирал Х.Батболд нь 2018 оны 07 дугаар сарын 23-ний 323 дугаар тогтоолоор 2,22 сая төгрөгийг 2017 оны үр дүнгийн урамшуулал авсан байна.

Мөн дээрх алдааг 2018 онд давтан гаргасан нь аудитын шалгалтаар илэрч 124.4 сая төгрөгийн бараа материалыг тайлант хугацааны зардалд тусгуулсан нь зардал өсөхөд нөлөөлжээ.

3.1 Зардлын задаргаа, хэтрэлт хэмнэлт:

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 он		Харь/ хувь	2018 он		Харь/ хувь
			Төлөв	Гүйц		Төлөв	Гүйц	
1	Цалингийн зардал	мян/төг	449005	396858.2	88.38	449839.4	398959.52	88.68
2	Ажил олгогчоос төлөх НДШ	мян/төг	72355.72	57544.43	79.52	65226.7	57848.98	88.68
3	Бичиг хэргийн зардал	мян/төг	2720	5859.6	259.27	2260	3671.03	162.43
4	Гэрэл цахилгаан, дулаан	мян/төг	8495.5	8381.3	98.65	7450.6	8766.76	117.66
5	Шатахуун	мян/төг	194668,3	181870,1	93,42	144714,4	173335,4	119,77
8	Шуудан холбоо	мян/төг	2720	1750,3	64,34	2720	2026,19	74,49
9	Албан томилолтын зардал	мян/төг	13044	18559,4	142,28	15398,3	25403,2	164,97
10	Сургалтын зардал	мян/төг	1370	1775	129,56	17830	14586,24	81,8
11	НХХЗардал	мян/төг	7777,3	7332	94,27	25178	26985,9	107,18
12	Элэгдлийн зардал	мян/төг	145101.2	152322.3	104.97	159600.7	102610.7	64.29
13	Сэлбэгийн зардал	мян/төг	78809,4	53261,46	67,58	77840,7	70464,03	90,52
14	Ахмадын сан	Мян/төг				3700	3700	100
15	Аудитын зардал	мян/төг	3000	0	-	4500	2990	66,44
16	Түрээсийн зардал	мян/төг	9500	4545,5	47,84	22500	12022,6	53,43
Ерөнхий удирдлагын зардал		мян/төг						
16	ББӨртөг	мян/төг	1146413,8	893346,2	77,9	1340640	1117916,8	83,38
17	Орлогын татвар, торгууль	мян/төг	-	-	-	-	22159,43	
18	Үндсэн данснаас хассаны гарз	мян/төг	-	-	-	-	-	-
19	ТУЗ-ын зардал	мян/төг	23188	15322,4	66,27	20718	22409,5	108,16
20	Бусад зардал	мян/төг	10150	22202,7	218,74	5650	6882,2	121,8
Нийт зардлын дүн		мян/төг	1254342	1121930,3	89,44	1334271,8	1344950,65	100,8

3.2 Орлого, зардал, үр ашгийн талаар 2017 онд үндсэн үйл ажиллагаанаас 1142,96 сая төгрөг, үйл ажиллагааны бус орлогоос 3.6 сая төгрөгийн нийт 1146,57 сая төгрөгийн орлого олж орлогын төлөвлөгөөг 98,01 хувиар, 1121,93 сая төгрөгийн зардал гаргаж зардлын төлөвлөгөөг 98.1 хувиар, 22,18 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, ашгийн төлөвлөгөөг 83,64 хувиар тус тус биелүүлж ажиллажээ.

2018 онд үндсэн үйл ажиллагаанаас 1016,2 сая төгрөгийн, үйл ажиллагааны бус орлогоос 3,9 сая төгрөгийн нийт 1020,1 сая нийт төгрөгийн орлого олж орлогын төлөвлөгөөг 74,6 хувиар, 1117,9 сая төгрөгийн зардал гаргаж, зардлын төлөвлөгөөг 100,8 хувиар, 320.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, ашгийн төлөвлөгөөг 320,9 хувиар тус тус тасалдуулснаар зорилтот түвшний биелэлтийг гаргажээ

2018 онд 320,95 сая төгрөгийн алдагдалтай гарсан шалтгаан нь 2017 онд тухайн жилийн зардалд бичигдэх байсан 124,4 сая төгрөгийн бараа материалын залруулга бичилт хийгдсэнээс болж үүссэн байна.

Зардлыг гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл шатахуун, албан томилолт, бичиг хэргийн зардлууд төлөвлөсөн хэмжээнээс давсан байна. Энэ нь тухайн үеийн

удирдлагууд шатахуун, албан томилолтын зардлаа хэт үрэлгэн хандсантай холбоотой байна

Мөн 2017, 2018 онуудад бүх ажлаа хийж дууссан байтал дуусаагүй үйлдвэрлэл дансанд 196,5 сая төгрөгийн үлдэгтэй байсныг аудитаар орлого үр дүнгийн тайланд хаасантай холбоотой.

3.3 Авлага, өглөгийн талаар: 2017 онд авлагын эхний үлдэгдэл 38.4 сая төгрөг байснаас оны эцэст нийт үлдэгдэл 344.41 сая төгрөг болж өссөн байна.

2018 оны авлагын эхний үлдэгдэл нийт 344.41 сая төгрөг байснаас тайлант хугацаанд 140.77 сая төгрөгөөр буурч, оны эцэст нийт үлдэгдэл 203.64 сая төгрөг болжээ.

- Ажилчдын хоолны суутгал /тайлант онд үүссэн авлага/ 89 мянган төгрөг
- Булган АЗЗА ТӨХК 2013 оноос хойш насжилттай авлага 22.1 сая төгрөг
- Орхон замын сан 2017 онд хийсэн ажлуудын баталгааны үлдэгдэл 11.6 сая төгрөг
- РСЦ ХХК 2017 онд хийсэн ажлын үлдэгдэл төлбөр 10.0 сая төгрөг
- Харбин электрик интернэшнэл ХХК-тай 2017 хийсэн гэгдэх 200.0 сая төгрөгийн гэрээт ажлын үлдэгдэл 160.0 сая төгрөгийн авлагатай гарчээ.

3.3.2 Өглөгийн талаар: 2017 онд богино хугацаат өр төлбөр оны эхэнд нийт үлдэгдэл 126,35 сая төгрөг байснаас тайлант хугацаанд 286,16 сая төгрөгөөр өсөж оны эцэст 412,52 сая төгрөг болсон үзүүлэлтэй байна. Урьдчилж олсон орлого дансанд хуурамчаар 235,16 сая төгрөг бүртгэснээс шалтгаалж богино хугацаат өр төлбөр өссөн байна.

2018 онд богино хугацаат өр төлбөр оны эхэнд нийт үлдэгдэл 412,52 сая төгрөг байснаас тайлант хугацаанд 174,21 сая төгрөгөөр буурч оны эцэст нийт үлдэгдэл 238,3 сая төгрөг болж буурсан үзүүлэлтэй байна. Урьдчилж олсон орлого дансанд хуурамчаар 235,16 сая төгрөг бүртгэснийг Аудитын шалгалтаар залруулсан нь 2018 оны богино хугацаат өр төлбөр буурахад нөлөөлсөн байна.

- НӨАТ 2016 оноос хойш хуримтлагдсан өглөг 200,44 сая төгрөг
- ХХОАТ 2017 оноос хойш өглөг 31,52 сая төгрөг
- “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-д 2018 онд үүссэн тосон будгийн үлдэгдэл төлбөр 2,62 сая төгрөг
- Түмэн үзэг ХХК бичиг хэргийн материалын үлдэгдэл төлбөр 0,17 сая төгрөг
- ШШГ Албанд ажилтнаас суутган авсан хүүхдийн тэтгэмжийн өглөг 0,16 сая төгрөг
- ҮЭ хороонд өгөх өглөг 3,38 сая төгрөг тус тус байна.

3.4 Урт хугацаат өр төлбөрийн талаар: Кувейтийн сангийн тусламж болох 626,89 сая төгрөгийн өглөг 2009 оноос хойш бүртгэлтэй байна.

3.5 Бараа материалын талаар: 2017 оны эхэнд 266,57 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан бол 2017 оны эцэст 381,46 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж, үлдэгдэл 114,89 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нэмэгдсэн шалгаан нь 2017 онд ашигтай гарахын тулд зардлыг бууруулах зорилгоор зарлагдсан бараа материалыг данснаас зарлагдаагүйтэй холбоотой байна. Дээрх үйлдэл санхүүгийн баримтаар нологдсон.

Тухайлбал: “Орхон-АЗЗА” ТӨХК нь 2017 онд 513.0 сая төгрөгийн бараа, материал худалдан авч, 549.6 сая төгрөгийн материалыг зарцуулснаар тайлагнасан байна.

Зам засварын ажилд зарцуулсан гэх 15.1 сая төгрөгийн давс, 10.0 сая төгрөгийн туузан хашлага, 13.2 сая төгрөгийн замын бодис, хайрга, 17.8 сая

төгрөгийн замын тэмдэг тэмдэглэгээ, 7.3 сая төгрөгийн асфальт, битумны үнэ, 4.1 сая төгрөгийн арматурын төмөр зэрэг нийт 67.6 сая төгрөгийн бараа материалыг худалдан авсан гэж хуурамч бичиг баримт бүрдүүлэн мөнгө зарцуулсан зөрчил илэрснийг Орхон аймаг дахь цагдаагийн газарт шалгаж, шалгалтын ажил явагдаж байна.

Дээр зөрчлийг хүснэгтээр харуулбал:

№	Гүйлгээний утга	огноо	Дүн	Борлуулагч
1	Давс авах	2017.01.31	1.460.0	"Ачуутсан" ХХК
2	Давс авах	2017.02.14	4.500.0	"Аниут" ХХК
3	Давс авах	2017.02.17	2.500.0	"Аниут" ХХК
4	Битум авах	2017.06.23	2.100.0	"Өлзий хутгийн наран" ХХК
5	Цас цэвэрлэгч бодис	2017.02.20	6.820.0	"Түмэн засал" ХХК
6	0,5 хайрга авах	2017.02.20	6.380.0	Удвал /иргэн/
7	Туузан хашлаганы урьдчилгаа	2017.07.06	10.000.0	"Ти би си Капитал" ХХК
8	Битум авах	2017.09.25	5.220.0	"Өлзий хутгийн наран" ХХК
9	Давс авах	2017.12.26	6.677.0	Ц.Алтангэрэл /иргэн /
10	Тэмдэг, тэмдэглэгээ	2017.07.06 2017.12.26	6.000.0 11.820.0	"Мөнх Хүдэр уул" ХХК
11	Арматур төмөр авах	2017.12.29	4.125.0	"Тэнгэрлэг цаг" ХХК
	Нийт		67,602,0	

2018 оны эхэнд 381,46 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан бол 2018 оны эцэст 24,57 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж, үлдэгдэл 356,89 сая төгрөгөөр хасагдсан байна. 2017 оны зарлагадаагүй бараа материалыг аудитаар залруулга хийж данснаас хассантай холбоотой байна.

3.6 Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын талаар: 2017 оны эхэнд 1395,3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байсан бол 2017 оны эцэст 1397,07 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж, үндсэн хөрөнгө 1,7 сая төгрөгийн тавилга эд хогшил худалдан авснаар нэмэгдсэн байна.

2018 онд үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 1397,07 сая төгрөг байсан бол 2018 оны эцсийн үлдэгдэл 1560,9 сая төгрөг болж үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 163,8 сая төгрөгийг тайлан балансад тусгаснаар өссөн байна.

3.7 Хөрөнгийн дахин үнэлгээний талаар: Монгол улсын Засгийн газрын 2016 оны 193-р тогтоолын дагуу Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг үнэлэх, санхүүгийн тайланд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлыг 2018 онд зохион байгуулагдсан.

Нийт 15,682.9 сая төгрөгийн үнэлгээ бүхий дахин үнэлгээ хийгдсэнээс балансад тусгагдсан:

Орхон АЗЗА ТӨХК-ын эзэмшилд нийт 7,102 м.кв бүхий 2 нэг төрлийн газрын эзэмших эрхийг дахин үнэлгээнд хамруулж үнэлсэн. Үүнд конторын болон аж ахуйн хашааны газруудыг эзэмших эрхийн бодит үнэ цэнийг 248,08 сая төгрөгөөр тогтоож дансанд шинээр бүртгэсэн байна.

Тус байгууллага нь үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээнд нийт 8 барилгыг үнэлгээнд хамруулсан байна. Барилгын нийт бодит үнэ цэнэ 267,57 сая төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгө болон нийтийн эзэмшлийн болон инженерийн байгууламжийг санхүүгийн тайлагналын зорилгоор норматив аргыг ашиглан барилгын адил аргачлалаар үнэлсэн байна. Тус байгууллага нь 10 хосын бэлэн сувагчлалын физик кабель бүхий 36м холбооны шугамтай байна. Үүний бодит үнэ цэнэ 0,113 сая төгрөг байна.

Мөн нийтийн эзэмшлийн байгууламжийн бодит үнэ цэнэ 33,8 сая төгрөгөөр үнэлгээ тогтоож дансанд тусгасан байна.

Дахин үнэлгээ 2018 онд хийгдэж ямар нэгэн зөрчил дутагдал үүсээгүй байна.

Дөрөв. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын тухайд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд зааснаар худалдан авалтын анхан шатны материал дутуу, худалдан авалтын анхан шатны хуурамчаар бүрдүүлж байгууллагад бараа материал орлогодож зарлагадсан. Хүний нөөц, бичиг хэрэг хариуцсан ажилтан Ш.Болорцэцэг нь Ажил үйлчилгээ, тендертэй холбоотой гэрээ, эрх зүйн баримт бичгийг өөрийн буруутай гэх зүйлдэлээр үргэдүүлдэг, шалгалтын үеээр түүнийгээ санаатайгаар нуун дарагдуулдаг, Тухайлбал: Хүний нөөц, бичиг хэрэг хариуцсан ажилтан Ш.Болорцэцэг нь “Орхон-АЗЗА” ТӨХК, “Өлзий хутгийн наран” ХХК-тай байгуулсан Асфальт бетон бэлтгэн нийлүүлэх гэрээг үргэдүүлсэн, “Өлзий хутгийн наран” ХХК-аас гэрээний нэг хувийг авчран албаны бичиг баримтаасаа олсон хэмээн хуурч төөрөгдүүлэх үйлдэл хийсэн.

Эрдэнэт үйлдвэрийн “Дулааны цахилгаан станцын турбины өргөтгөлийн ажлыг гүйцэтгэж буй БНХАУ-ын Харин elektrik интернэшнл ХХК-тай “Орхон-АЗЗА” ТӨХК-нь 200.0 сая төгрөгийн гэрээ байгуулан, туслан гүйцэтгэгчээр ажиллаж, гаднах бетон замын хучилт болон явган хүний замын ажлыг гүйцэтгэсэн боловч Харбин elektrik интернэшнэл ХХК-тай байгуулсан гэрээний эх хувь байхгүй. Тус ажилд 7.3 сая төгрөгийн хайрга, элс, 4.4 сая төгрөгийн цемент, 6.6 сая төгрөгийн төмөр, төмөр эд зүйлс, 10.1 сая төгрөгийн замын хавтан, хашлага, 80.4 сая төгрөгийн бетон зуурмаг, 5.3 сая төгрөгийн бусад материал, нийт 113.9 сая төгрөгийн бараа материал зарцуулсанаар тайлагнасан байна. Уг ажлын хөлс болгон тухайн компаниас 70 сая төгрөгийг урдчилгаа болгон өгсөн боловч, хувь хүний данснаас байгууллагийн дансанд 40 сая төгрөг шилжин орсон нь мөн Орхон аймгийн цагдаагийн газарт шалгагдаж байна.

Шатахуун зарцуулалтын анхан шатны баримтаас үзэхэд жолоочийн тооцооны хуудасгүй зарцуулж, байгууллагын хэмжээнд хэдэн литр шатахуун зарцуулсан тодорхойгүй байна.

Шалгалтын хамрагдах хугацаанд ажиллаж байсан ерөнхий нягтлан Ч.Жаргалмаа нь одоо хүртэл ажлаа хүлээлгэж өгөөгүй, дээрх хууль бус үйлдүүд нь гүйцэтгэх захиралаар ажиллаж байсан Х.Батболд, ерөнхий нягтлан бодогч Ч.Жаргалмаа нартай холбоотой болох нь тогтоогдсон. “Орхон-АЗЗА” ТӨХК-тай тогтмол хамтран үйл ажиллагаа явуулдаг “Өлзий хутгийн наран” ХХК-ийн удирдлагуудтай гүйцэтгэх захирал Х.Батболд нь үгсэн хуйвалдаж 2017 оны 06 дугаар сарын 23-ний өдрийн Битум авах гэрээ хийж 2.1 сая төгрөгийг иргэн н.Нарангэрэлд ажлын хөлс болгон өгсөн, иргэн н.Нарангэрэл нь Эрдэнэт үйлдвэрийн “Дулааны цахилгаан станцын турбины өргөтгөлийн ажлыг гүйцэтгэж буй БНХАУ-ын Харин elektrik интернэшнл ХХК-тай “Орхон-АЗЗА” ТӨХК-нь туслан гүйцэтгэгчээр 200.0 сая төгрөгний гэрээ байгуулсан дагуу “Орхон-АЗЗА” ТӨХК-д нэрийн өмнөөс ажлын даамлаар ажилласны хөлс болгон авсан байна.

Мөн Гүйцэтгэх захирал Б.Цогтгэрэлийн албаны зориулалтаар ашиглагдаж байсан 00-21 улсын дугаартай “Орхон-АЗЗА” ТӨХК-ийн хөрөнгөд бүртгэлтэй ланд крузейр-100 маркийн авто машиныг түүний хүү “Өлзий хутгийн наран” ХХК-ын захирал Ц.Гантулга нь хувийн хэрэгцээндээ 2019 оны 03 дугаар сараас хойш ашиглаж байсныг шалгалтаар тогтоож баримтжуулан дээрх авто машиныг хураан авч байгууллагын хашаанд бүтүүмжилж зогсоосон, гүйцэтгэх захирал Б.Цогтгэрэл нь тухайн үйлдлээ тайлбарлахдаа 00-21-оор улсын дугаартай авто машин нь өнгө үзэмж муудсан болохоор би голоод унадаггүй манай хүү унаж байгаа гэж тайлбар өгсөн. Ланд-крузейр-100 маркийн 00-21 оор улсын дугаартай авто машины 2019 оны 03 дугаар сараас 08 дугаар сарын хооронд шатахуун зарцуулалт нь нийт: 3,8 сая төгрөг байна. Шатахуун зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл дутуу, жолоочийн тооцоо нийлсэн хуудас байхгүй байна.

Тус байгууллагын 2017-2018 онуудад аж ахуй няраваар ажиллаж байсан Б.Мөнхцэцэг нь эд хариуцагчийн агуулахын бүртгэл хөтөлдөггүй, бараа материалын дэлгэрэнгүй тайлан гаргадаггүй зөвхөн сахиулын нь өөрийн бүртгэлийн дэвтэрт тэмдэглэлдэг байна. Мөн кассын нярав касснаас бэлэн мөнгө авч бараа материалын төлбөр төлөхдөө тухайн байгууллагад бус өөрийн байгууллагын захирал, ерөнхий нягтлан бодогчоор дамжуулан өгдөг ч цаад байгууллагын бэлэн мөнгөний ордер байхгүй байна.

4.2. Тендер, худалдан авалттай холбоотой зөрчлийн талаар:

“Өлзий хутгийн наран” ХХК нь 2017 оны 05 дугаар сарын 18-ны 09 дүгээр гэрээгээр 450 тн, 09 дүгээр сарын 11-ний өдрийн 10 дугаар гэрээгээр 300 тн, 10 дугаар сарын 06-ны өдрийн 10 дугаар гэрээгээр 300 тн, нийт 204,7 сая төгрөгийн 1,050,0 тн асфальт бетонийг “Орхон-АЗЗА” ТӨХК-д нийлүүлэхээр гэрээ байгуулсан байхад 262.2 сая төгрөгийн 1,318,6 тн асфальтыг “Өлзий хутгийн наран” ХХК-аас авсан зарлагын баримт, тооцоо нийлсэн акт үйлдсэн ч “Орхон-АЗЗА” ТӨХК нь 2017 оны бараа материалын тайланд огт тусгаагүй байна. Энэ нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13,4-т “Аж ахуй нэгж” байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гаргасан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичигт хийж баталгаажуулна гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.3. Дээд байгууллагын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн талаар:

Удирдах дээд байгууллага болох Зам тээврийн яамнаас 2017 онд нийт 13 бичиг ирснээс хариутай 8, хариугүй 5 бичиг байна. 2018 онд нийт 8 албан бичиг ирснээс хариутай 5, хариугүй 3 бичиг байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2017 онд нийт 33 албан бичиг ирснээс хариутай 22, хариугүй 11 бичиг ирсэн байна. 2018 онд нийт 28 албан бичиг ирснээс хариутай 18, хариугүй 10 бичиг ирсэн байна. Дээрд газраас өгөгдсөн үүрэг даалгавар, тогтоол шийдвэр биелүүлэлт хангалттай байна. “Орхон-АЗЗА” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Х.Батболд нь 2017 онд А тушаал 52, Б тушаал 37, 2018 онд А тушаал 47, Б тушаал 24, тус тус тушаалууд гаргасан байна. Дээрх тушаал шийдвэртэй холбоотойгоор ямар нэгэн хөдөлмөрийн маргаан гараагүй байна.

Тав. Дүгнэлт, зөвлөмж цаашид авах арга хэмжээ

Бараа материалыг анхан шатны баримтын бүрдэл дутуу, тайланд бүрэн тусгадаггүй, хуурамч бичиг баримт бүрдүүлж хөрөнгө зарцуулсан, ажилчидтай холбоотой зардлыг тооцоогүй, хяналтгүй зарцуулсан байна. Орлогын төлөвлөгөө 282.5 сая төгрөгөөр тасарч, өмнөх оноос авлага 305.9 сая төгрөгөөр, өр төлбөр 188.2 сая төгрөгөөр өссөнөөс, 125.2 сая төгрөгийн өглөг, 2017 онд тайланд РСЦ ххк-аас авах 10.0 сая төгрөгийн авлагыг тайлан бүртгэлд тусгаагүй байсан. Мөн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт хангагдаагүй байна.

Зөвлөмж:

- Тухайн жилийн зорилтот түвшин, түүний хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг эдийн засгийн үндэслэлтэй төлөвлөж батлуулах;
- Шилэн дансны тухай хуулийн дагуу цахим хуудсанд холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь оруулах;
- Үндсэн хөрөнгө олж авахдаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авах;
- Байгууллагын эд хөрөнгийг өөрт олгогдсон эрх хэмжээний дотор захиран зарцуулах;

- Анхан шатны баримт материалын бүрдэлгүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусгахгүй байх;
- “Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хууль, тогтоомжийн дагуу худалдан авалтыг төлөвлөж, зохион байгуулж, тайлагнах;
- Байгууллагын хөрөнгийг зохистой удирдаж авлага өглөгийг бууруулж ажиллах, хугацаа хэтэрсэн авлагыг шүүхийн журмаар шийдвэрлүүлэх;

ТӨБХХ-ийн ахлах мэргэжилтэн,
улсын ахлах байцаагч

Н.Ган-эрдэнэ

ТӨБХХ-ийн мэргэжилтэн

Т.Анхбаяр

Зөвшөөрсөн:

“Орхон-АЗЗА” ТӨХК-ийн захирал

Б.Цогтгэрэл

“Орхон-АЗЗА” ТӨХК-ийн”
ерөнхий санхүүч

Т.Ганболд